




Тоттори-кэн аялалын танилцуулга (англи хэл)

<http://www.tottori-guide.jp/>

ACCESS

✈️ (Онгоцоор)

- Токио (Ханада)-с Тоттори Сакюу Конан нисэх онгоцны буудал (70мин орчим)
- Токио (Ханада)-с Ёнаго Китаро нисэх онгоцны буудал (80мин орчим)
- Сөул (Инчён олон улс)-с Ёнаго Китаро нисэх онгоцны буудал (1цаг 40мин орчим)
- Хонконг (Хонконг олон улс)-с Ёнаго Китаро нисэх онгоцны буудал (3цаг орчим)



🚗 (Цахилгаан тэрэгээр)

Токиогоос (5цаг орчим)

Шинкансэн→

Шина Осакад дамжиж→

Супер Хакуто...Тоттори буудал

Нагоя-с (3цаг 20мин орчим)

Шинкансэн→

Химе жид дамжиж→Супер

Хакуто...Тоттори буудал

Оосакагаас

(2цаг 30мин орчим)

Супер Хакуто...Тоттори буудал

🚗 (Машинаар)

Нагоя-с (4цаг 30мин орчим)

Меишин хурдны зам→Чоугоку

автомашини зам→СаёJCT→

Тоттори автомашины зам...Тоттори

Оосакагаас

(2цаг 30мин орчим)

Чоугоку автомашины зам→

Са JCT→Тоттори автомашины зам...Тоттори


🚗 (Хурдны автобусаар)

Токиогоос

(10цаг 10мин орчим)

Оосака, Кобе-с

(2цаг 50мин орчим)



Тоттори-кэн доторх нийтийн талбайн гольф ийшээ (япон хэл)

<http://www.groundgolf.or.jp/tabid/59/catid/40default.aspx>

Лавлах

Тоттори орон нутгийн хөгжлийн газар
Спортын хэсэг



sports@pref.tottori.lg.jp

FAX.+81-857-26-8108

〒680-8570

Тоттори-кэн, Тоттори-ши, Хигаши-мачи, 1-220

За, ЭХЭЛЦГЭЭ

Хаана ч

Хэн ч

Хялбар

Талбайн гольф



Талбайн гольф бий болсон газар, Тоттори-кэн!

Талбайн гольфын талаархи бүгд энэ нэг номонд!!

- Түүх
- Уралдааны товч
- Хэрэглэл
- Дүрэм...

GUIDE BOOK



Тоттори-кэнд бий болсон талбайн гольф

Талбайн гольф нь, өндөр төвшний техник шаардахгүй, дээр нь бүх хүчээ гаргах хэсэг болон, анхаарлаа төвлөрүүлэх болон тохируулах чадвараа гаргах хэсэг тохиромжтойгоор орсон бөгөөд, дүрэм нь бас энгийн.

Анх удаа байсан ч хурдан сурч, өндөр настнаас гадна янз бүрийн үе насны хүмүүсийн дунд дэлгэрч байгаа бөгөөд, дотоодоос гадна, гадаад улсад хүртэл дэлгэрч байна.

Яагаад талбайн гэдэг нэр өгсөн бэ...

Гольфын талбай руу очилгүй, газар нутгийн гадаахи биеийн

[хаана ч], [хэн ч], [хялбархан]



тамирын талбай (талбай)-д ч боломжтой спортыг төсөөлөн, [хаана ч], [хэн ч], [хялбархан] чадах спортыг зорисон учраас.



Тоттори элсэн нуруу

Сан-ин Кайган Геопарк
Урадоме Кайган



Талбайн гольфын онцлог

1 Хаана ч боломжтой

Стандарчлагдсан курс шаардлагагүй. Тоглогчын зорилго, орчин, чадвар, зэрэгт тохируулан, биеийн тамирын талбай, толгод, цэцэрлэг, талбай зэрэг хаана ч, чөлөөтэй курс бэлдэх боломжтой.

2 Бэлтгэл хялбар

Гольф шиг нүх ухах шаардлагагүй, бариаг босгоход бэлэн болно.

3 Дүрэм нь хялбар

Бусад спорттой харьцуулхад, дүрэм нь маш хялбар бөгөөд, нэг удаа тоглоход цээжилнэ.

4 Тоглогчын тоо хязгааргүй

Талбайн гольф нь, ганцаараа ч, эсвэл талбай хүрэлцвэл хэдэн зуун хүн ч тоглох боломжтой. Бөмбөг нь агаарт хөөрөхгүй тул, барианы байршлыг тохируулбал, бүх барианаас зэрэг эхэлсэн ч, аюулгүй тоглох боломжтой.

5 Шүүх нь та өөрөө

Тоглолт дундын шүүх нь тоглогч өөрөө гүйцэтгэнэ. Шийдвэрлэхэд амаргүй тохиолдолд, хамтран тоглогчын зөвшөөрлийг шаардана.

6 Өндөр техник байхгүй байсан ч чадна

Талбайн гольфын техник нь бусад уралдаан тэмцээнтэй адилаар, бэлтгэл хийж сайжирч, өрсөлдөх чадвар дээшлэнэ. Гэхдээ, тоглолтоор хөгжилдөхөд заавалчгүй өндөр техник шаардлагагүй. Хүүхдээс эхлээд өндөр настан хүртэл бүх хүмүүс, хөгжилдөн толгох боломжтой. Тиймээс, талбайн гольф нь гэр бүлийн спорт болгон хөгжилдөх нөхцөлийг бүгдийг бүрдүүлсэн спорт юм.

7 Цаг хугацааны хязгаар байхгүй

Тоглолын хугацаа тогтоогдоогүй тул, цаганд баригдалгүй, чадварын хэмжээ болон хамтрагчын тоо, эсвэл курсын онцлогт тааруулан, тоглолтыг хөгжилдөх боломжтой.



Талбайн гольф гэдэг нь




Дүрмийн хураангуй.

Зориулалтын цохиур, бөмбөг, бариа, эхлэх хэсгийг ашиглан, гольф шиг бөмбөгийг цохиураар цохиж, бариад оруулах хүртэлх зохисон тоог тоолно.

Курс

Стандарт курс, 50м, 30м, 25м,15м тус бүр 2 хэсэг нийт 8 хэсгээс бүрдэнэ.



1 Биеэ авч явах байдал

Тоглогч, өөрийн тоглолт дуусахаар, түргэн дараагийн тоглогчид саад болхооргүй газар очих



Тоглогч, хамтрагч тоглогч нь цохисон тохиолдолд, ярих, хамтрагч тоглогчын бөмбөг болон барианы ойролцоо, тоглогчын өмнө болон ард зогсохгүй, өөрсдийн өмнөх баг дуусах хүртэл, бөмбөг цохихгүй.



Тоглогч, өөрийн бий болгосон нүх болон хөлийн мөрийг янзалж явна.

Энэ тохиолдолд яах вэ?

Q1 Өмнөх тоглогч нүхээ янзалалгүй явах. Энэ нүхийг янзлах ёстой юу?

A Тийм. Болно. Гэхдээ, байгалын хотгор түвгэрыг янзалж болохгүй.



2 Тоглоомыг үргэлжлүүлэх арга

Бөмбөгийг тогтоосон цохих дарааллын дагуу эхлэлээс цохиж эхлэн, бариа доторхи зогссон байдал (Томари) хүртэл цохисон тоог тоолно.

Цохих дараалал Тоглоом эхлэхийн өмнө, ямар цохих дарааллаар хийхийг шийднэ. (Тогтсон дүрэм болон, ээлжлэх дүрэм 2 янз байдаг)

Тогтсон дүрэм

1 2 3 4 5 6

A B C D E F

(Жишээ) 1 барианы цохих дараалал
A→B→C→D→E→F
2 барианы цохих дараалал
A→B→C→D→E→F
...

Ээлжлэх дүрэм

← Дарааллаар солигдох →

A B C D E F A

↑ Үрт байсан хүн хамгийн сүүлд ↓

(Жишээ) 1 барианы цохих дараалал
A→B→C→D→E→F
2 барианы цохих дараалал
A→B→C→D→E→F
3 барианы цохих дараалал
C→D→E→F→A→B
...

Энэ тохиолдолд яах вэ?

Q2 Цохих дараалал андуурсан тохиолдолд яах вэ?

A Бусад тоглогч зөвшөөрвөл, дараагийн цохилтоос өмнөх цохилтын дараалалд буцаах. Гэхдээ, бусад тоглогч дахин цохихыг шаардсан тохиолдолд зөв цохих дарааллын дагуу тоглолтыг засч хийх. (1 нэмэлт цохилтгүй)

Q3 Андуураад, бусад тоглогчын бариаг цохивол?

A Бөмбөгийн эзэн нь өмнөх байрлалд буцаана. (1 нэмэлт цохилтгүй)

Угсруулан цохих Нэг хүн [Томари] болох хүртэл цохиж үргэлжлүүлэх, өөрөөр хэлбэл угсруулан зохилт хийхгүй.

POINT


«Гэхдээ, цохиурын» урттай байрлал, барианд ойртсон бөмбөгийг үргэлжлүүлэн цохих боломжтой.



Энэ тохиолдолд яах вэ?


Q4 Бөмбөг барианы суурь цагирагын дээр нь зогссон тохиолдолд, [Томари]-д тооцох уу?

A Тийм. [Томари]-д тооцоно.



3 Хэрэглэл

Цохиур, бөмбөг, бариа, эхлэл гэсэн тогтсон зүйлсийг хэрэглэхгүй бол болохгүй.



Салхинд унахгүйн тулд хүндрүүлэгч болон хэдаасаар бэхлэх.

check

Цохиур нь лентээр ороож болох боловч, түүнээс өөрөөр өөрчлөхийг хориглоно.



Бөмбөг тогтоогч бэхэлсэн чигтээ тоглохыг өөрчилсөн гэж үзнэ.



4 Тоглоомын дундахь цохилтын бэлтгэл

Тоглогч, тоглолтын дунд ямар ч цохилтын бэлтгэл хийж болохгүй. (зөрчвөл 1 цохилт нэмнэ)



5 Туслалцаа

Тоглогч, цохих үед, зүйлс болон хүний туслалцаа болон зөвлөгөө зэрэгийг шаардах, авч болохгүй.

6 Бөмбөгийг байгаа байдлаар нь тоглох

Тоглогч, цохисон бөмбөг нь өвс мод зэрэгийн дунд орсон тохиолдолд, бөмбөгний байрлал болон өөрийн бөмбөг мөн болох эсэхийг шалгах хүрээнд, эдгээрт хүрэх боломжтой. Өвс таслах, модны мөчир хугалан тоглолт хийж болохгүй.



7 Бөмбөг цохих аргачилал

Тоглогч, бөмбөг цохих үед, цохиурын толгойгоор зөв цохиж, түлхэж гаргах, татаж ойртуулахгүй. (зөрчвөл 1 цохилт нэмнэ)

check



Ар өвөр аль аль нь хавтгай тохиолдолд аль нь ч цохих тал болно



Чичрэлт болон салхины даралтаар, бөмбөгийг цохиогүй үед өнхөрсөн тохиолдолд, шинээр цохиж болно.

8 Алга болсон бөмбөг болон гаднах бөмбөг

Тоглогч, цохисон бөмбөг нь алга болох, курсын гадна гарсан тохиолдолд 1 цохилт нэмж, барианд ойртолгүй, тоглох боломжтой байрлалд бөмбөгийг орхиж, дараагийг цохино.

Бөмбөгийг бусад газар шилжүүлэхгүй бол цохих боломжгүй тохиолдолд, бөмбөг харагдахгүй газар болон унасан газраас, цохиур 1 ширхэгийн уртын хүрээнд дотор шилжүүлж болно.




9 Тоглолтод саад болох бөмбөг

Тоглогч, тоглолтод саад болох бөмбөгийг, хэсэг хугацаагаар авч зайчлах боломжтой. Авч зайчлуулахыг бөлбөгийн эзэн гүйцэтгэнэ. Тэр үед, барианы эсрэг, бөмбөгийн ард тэмдэг тавьж авч зайлуулна.



10 Бусад тоглогч бөмбөгт хүрсэн тохиолдолд.

Тоглогч, цохисон бөмбөг нь бусад тоглогчын бөмбөгөнд хүрсэн тохиолдолд, бөмбөг зогссон байрлалаас тоглолтыг үргэлжлүүлнэ. Бөмбөг нь хүрсэн тоглогч өмнөх байрлалд бөмбөгийг буцаана.



Энэ тохиолдолд яах вэ?

Q5 Цохисон бөмбөг нь бусад тоглогчын бөмбөгөнд хүрч [Томари] болсон тохиолдолд, яах вэ? Мөн хүрсэн бөмбөг нь [Томари] болсон тохиолдолд?

A Цохисон тоглогчын бөмбөг бол [Томари]. Бөмбөг нь хүрсэн тоглогчын бөмбөг бол [Томари] биш. Өмнөх байрлалд буцаана.

Q6 Тоглогч зэрэгт бөмбөг хүрсэн тохиолдолд, яах вэ?

A Жижиг чулуу болон мөчиртэй адил саад гэж үзэн, бөмбөг зогссон байрлалаас дараагын тоглолт.

11 Зогссон бөмбөг салхиар хөдөлсөн үед

Тоглогч, цохисон бөмбөг хөдөлж байгаа үед, бөмбөгийг зохиж болохгүй. Салхиар хөдөлсөн үед, зогссон газраас тоглож, хөдлөн барианд орсон тохиолдолд Томари гэж үзнэ.



12 1-р цохилтоор барианд орсон тохиолдолд (хоорү ин ван)

Тоглогч, цохисон бөмбөг нь 1рхээр Томари болсон үед (хоорү ин ван), нийт цохисон тооноос 1 удаа 3 цохилт хасч тооцно.

13 Онооны карт бөглөх аргачлал

Цохих тоо: Бариа бүрийн цохих тоо (тооцсон тоогоор бөглөх)

Өөрийн курсын дараалалд барианы дугаарыг бичнэ.

Нэр бичих (цохих дараалал)

Нийлбэр: Одоо хүртэлх нийт цохисон тоо

Бодит цохисон тоо - (1 цохисон тоо x 3)

Хоорү ин ваны тоо. 1 хоорү ин ванд, -3 цохилт.

大会名 () ()		コース スタートホール ()		期 年 月 日 ()															
No.	氏名	1	2	3	4	5	6	7	8	実打数	1打目	合計	補正						
1	○○○○	3	6	9	5	14	7	21	3	24	3	27	5	32	1	33	33	1	30
2	△△△△	5	7	12	5	6	23	28	31	33	36								
3																			

POINT Хоорү ин ваны тохиолдолд, цохилтын тооны мөрөнд [1] болон [-] гэж бичих, нийлбэрийн мөрөнд 1-г нэмсэн тоог бичнэ. Нийлбэр мөрөнд 1 хоорү ин ванд 3-г хассан тоог бичнэ.